



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 22 өдөр

Дугаар A/54

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай

Авлигын эсрэг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6, 23.2, Монгол Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, шалгах журам”-ын 3.5-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны А/196 дугаар тушаалын 1 дэх хэсгийн “хоёрдугаар хавсралтаар” гэсний дараа “Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг гуравдугаар хавсралтаар” гэж, мөн тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам”-ын “Гурав” дугаар зүйлд “3.2. Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх ажлыг жилийн бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор зохион байгуулж, дүнг харъяалах байгууллагад нь мэдэгдэнэ” гэсэн хэсгийг тус тус нэмсүгэй.

2. Журамд заасны дагуу эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх ажлыг тогтоосон хугацаанд зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Ж.Батсайхан, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Б.Бат-Отгон нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар /З.Баасанням/-д даалгасугай.

ДЭД ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Ц.НЯМДОРЖ

ХУУЛБАР ҮНЭН:

Тамгын хэлтсийн дарга,
эрхэлсэн комиссар

З.БААСАННЯМ



000607

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

УХА0477-5120829

Д/д	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих 100 оноо	Тайлбар
Нэг. Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналтын үйл ажиллагаа /50 оноо/			
1.1. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа:		27 хүртэл	
1.1.1	Мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг хугацаанд нь зохих журмын дагуу ирүүлж, хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтныг бүрэн хамруулсан байдал	3	ХШДШХ үнэлэх
1.1.2	Авлигатай тэмцэх газрын даргын 2012.06.13-ны өдрийн 91 дүгээр тушаалын 1, 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3 тайлангийн үнэн бодит байдлыг хангаж, хугацаанд нь ирүүлсэн байдал	6	
1.1.3	Авлигатай тэмцэх газрын даргын 2012.06.13-ны өдрийн 91 дүгээр тушаалын 4, 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан ХАСХОМ, ХАСУМ, ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар мэдэгдэл, тайлбар гаргасан тухай бүртгэлийг маягтын дагуу хөтөлж, бүртгэсэн байдал	6	
1.1.4	Мэдүүлгийн цахим систем ашиглалт, мэдүүлгийг цахим хэлбэрээр бүрэн авч баталгаажуулсан байдал болон "ЭБАТ" цэсний бүртгэлүүдийг тогтмол бүрэн хөтөлсөн байдал	6	
1.1.5	ХАСХОМ, ХАСУМ, ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар мэдэгдэл, тайлбар гаргах талаар гарын авлага боловсруулж, сургалт зохион байгуулан, харъяа нэгж байгууллагын ЭБАТ-ны үйл ажиллагаанд хяналт тавьж, заавар зөвлөмжөөр хангасан байдал	6	
1.2. Мэдүүлгийн хяналт шалгалтын үйл ажиллагаа:		23 хүртэл	
1.2.1	Авлигатай тэмцэх газраас илрүүлсэн зөрчлийг арилган холбогдох арга хэмжээ авч, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал	6	ХШДШХ үнэлэх
1.2.2	Авлигатай тэмцэх газраас шаардсан мэдүүлэг, бусад баримт бичгийг хугацаанд нь ирүүлж, мэдүүлгийн хадгалалт, хамгаалалт, нууцлалыг хангах талаар болон мэдүүлгийн талаар мэдээлэл өгөхдөө холбогдох журмыг баримталсан байдал	6	
1.2.3	ХАСХОМ болон ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар мэдэгдэл, тайлбарыг хугацаанд нь гаргуулж, ХАСУМ-ийг хууль тогтоомжийн дагуу Авлигатай тэмцэх газарт хянуулж хэвшүүлсэн байдал	6	
1.2.4	Авлигатай тэмцэх газраас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, үр дүн, хариутай албан бичгийн шийдвэрлэлт	3	
1.2.5	Авлига, ашиг сонирхлын зөрчил, хууль зөрчсөн асуудлаар АТГ-т мэдэгдэн, шилжүүлж шалгуулсан байдал	2	
Хоёр. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа /25 оноо/			
2.1. Төлөвлөлт, тайлагналтын үйл ажиллагаа:		20 хүртэл	
2.1.1	Тухайн жилийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хугацаанд нь ирүүлсэн байдал /төлөвлөгөөний төсөлд санал авсан байх/	10	УССГХ үнэлэх

2.1.2	Тухайн жилийн авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан /төлөвлөгөөний хэрэгжилт/-г хургацаанд нь ирүүлсэн байдал	10	
2.2.	Авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүн	5 хүртэл	
2.2.1	Авлигын эсрэг үйл ажиллагааны тухайн жилийн үнэлгээ өмнөх оны үнэлгээнээс нэмэгдсэн, буурсан байдал	5	УССГХ үнэлэх
Гурав. Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа болон идэвх санаачилга / 25 оноо/			
3.1.	Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа:	10 хүртэл	
3.1.1	АТГ-аас авах сургалтын захиалга, хамтран хэрэгжүүлэх соён гэгээрүүлэх ажлын санал ирүүлсэн байдал	5	УССГХ үнэлэх
3.1.2	Бие даан хэрэгжүүлсэн сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх чиглэлээр тусгайлан зохион байгуулсан ажил, арга хэмжээ	2	УССГХ үнэлэх
		3	ХШДШХ үнэлэх
3.2.	Идэвх санаачилга:	15 хүртэл	
3.2.1	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үйлчилгээний хүртээмж, хүнд суртал, чирэгдлийг багасгах болон цахим хуудасны мэдээллийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ	5	УССГХ үнэлэх
3.2.2	Мэдүүлгийн бүрдүүлэлтийн асуудлаар цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа, санал санаачилга	2	ХШДШХ үнэлэх
3.2.3	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох чиглэлээр гаргасан санал, хүсэлт	2	ХШДШХ үнэлэх
		3	УССГХ үнэлэх
3.2.4	Эрх бүхий албан тушаалтны болон мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд тулгамдаж буй бэрхшээл, түүнийг арилгах арга замын талаарх санал	3	ХШДШХ үнэлэх

Тайлбар: Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг тухайн жилийн 11 дүгээр сарын 15-ны дотор Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст, Төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны бичмэл тайланг мэдүүлгийн бүрдүүлэлтийн мэдээ, тайлан /өмнөх оны 3 дугаар сарын 1-нээс тухайн оны 3 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамруулж ойлгоно/-ийн хамт дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст тус тус хаяглан ирүүлнэ. Тайланд:

- ❖ “Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийн 1.1.1-1.1.5, 1.2.1-1.2.5, 3.1.1-3.1.2, 3.2.1-3.2.4-т дурдсан үзүүлэлт тус бүрээр хийсэн ажлыг дэлгэрэнгүй бичих;
- ❖ Дээрх үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэр, баримт, материал /батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, фото зураг, видео бичлэг гэх мэт/-ын хуулбарыг баримтжуулан хавсарган ирүүлнэ.

Үнэлгээ:

- ❖ 0-50 бол “хангалтгүй”;
- ❖ 50-70 бол “дутагдалтай”;
- ❖ 70-90 бол “хангалттай”;
- ❖ 90-100 бол “маш сайн” гэж үнэлнэ.